



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 10 сарын 21 өдөр
54

Дугаар

Төрийн ордон, Улаанбаатар хот

Мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай

[/Тогтоолын нэрэнд 2012 оны 02 сарын 16-ны өдрийн 19 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 19^{1.6} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 200000 /хоёр зуун мянган/ төгрөгөөр, “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг 100000 /нэг зуун мянган/ төгрөгөөр тус тус өөрчлөн тогтоож, 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

[/Энэ заалтад 2012 оны 02 сарын 16-ны өдрийн 19 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эхийн алдар” одонтой эхэд 2010 онд олгох мөнгөн тусламжийн зөрүүг 2010 оны 4 дүгээр улиралд багтаан олгохыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тэтгэмжийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2007 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоол, “Мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

Д.ДЭМБЭРЭЛ
